



СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХ УРИЛГА

2025 оны 07 сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 06 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө”-нд орсон дараах ажлыг гүйцэтгэх байгууллагыг сонгон шалгаруулах шалгаруулалтад оролцохыг урьж байна.

Сонгон шалгаруулалтын нэр: Мал, амьтны эмнэлэг, эрүүл ахуй, ариун цэврийн лабораториуд, мал амьтны эмийн үйлдвэр болон эмийн санд ажиллагчдын үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогод өртөж буй шалтгаан нөхцөлд тандалт судалгаа хийж, дүгнэлт гарган холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх

Ажлын даалгавар татаж авах холбоос: <https://publuu.com/flip-book/915678/2007917>

Төсөвт өртөг: 15 000 000 төгрөг

Сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн эрх бүхий оролцогч нь энэхүү урилгад заасан холбогдох хаягаар Захиалагчаас ажлын өдрүүдэд 08:00-16:00 цагийн хооронд нэмэлт мэдээлэл авч болно.

Сонгон шалгаруулалтад ирүүлэх саналаа 2025 оны 07 дугаар сарын 01-ээс 07 дугаар сарын 07-ны өдрийн 17:00 цагт эсхүл түүнээс өмнө урилгад заасан хаягаар ирүүлнэ. Хугацаа хоцорсон саналыг хүлээн авахаас татгалзана.

Сонирхсон оролцогч нь Захиалагчид Монгол хэл дээр бэлтгэгдсэн Сонгон шалгаруулалтын баримт бичгийг битүүмжлэн цаасаар 2% (хоёр хувь) болон pdf өргөтгөлтэй файл хэлбэрээр ирүүлнэ үү.

Санал хүлээн авах хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Хөдөлмөрийн ордон, 4-н давхар, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 409 тоот

Холбоо барих утас, цахим шуудангийн хаяг: 7714-4949, 7712-4949, Bnarantsetseg@osh.gov.mn

Санал бэлтгэх эсхүл хүргэхтэй холбоотойгоор сонгон шалгаруулалтад оролцогчийн зүгээс гаргасан аливаа зардлыг Захиалагч хариуцахгүй.

Цахим шуудангаар илгээсэн баримт бичиг, тодруулга хугацаа хоцорч хүргэгдсэнтэй холбоотойгоор Захиалагч ямар нэг хариуцлага хүлээхгүй.